

**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ  
БЭЛТГЭСЭН ТАЛААРХ НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 04 дүгээр  
сарын 28-ны өдөр

Улаанбаатар  
ХОТ

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн  
Д.Сарангэрэл**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2015 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай асуудлыг тус Байнгын хороо 2015 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийх үеэр Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн менежментийг сайжруулах, хуулийн төсөлд тусгагдсан аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах зардлын хувь хэмжээг бууруулах, Улсын Их Хурлын гишүүн А.Бакей амь насаа алдсан, хохирсон иргэдэд олгох нөхөн төлбөрийг ялгамжтай тогтоох, ажил олгогчийн хүлээх үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл олон улсын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, Улсын Их Хурлын Н.Номтойбаяр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээнд зарцуулж буй зардалд эдийн засгийн тооцоо судалгаа хийх, Улсын Их Хурлын гишүүн Ё.Отгонбаяр ажлын байран дахь эрсдлийн түвшингээс хамааран зарцуулах зардлын хэмжээг тогтоох, Улсын Их Хурлын гишүүн А.Тлейхан ерөнхий гүйцэтгэгчийн хүлээх үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх зэрэг зарчмын зөрүүтэй саналыг гаргалаа.

Байнгын хорооны хуралдаан дээр Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж, саналын томъёоллыг Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Д.БАТЦОГТ**

**Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд нэмэлт,  
өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх  
зарчмын зөрүүтэй саналын томьёолол**

**Нэг.Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо  
дэмжсэн санал:**

**1.Хуулийн төслийн 26.2 дахь хэсгийн “аж ахуйн нэгж, байгууллага” гэсний дараа  
“эрсдэлийн түвшингээс хамааран” гэж нэмэх.**

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн Ё.Отгонбаяр, Л.Энх-Амгалан**

**2.Хуулийн төслийн 26.2 дахь хэсгийн “2.0 хувиас” гэснийг “1.5 хувиас” гэж  
өөрчлөх.**

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн Ё.Отгонбаяр, Л.Энх-Амгалан**

**3.Хуулийн төслийн 26.2 дахь хэсгийн “тус тус зарцуулна.” гэсний дараа “Аж ахуйн  
нэгжүүд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн олон улсын стандартыг нэвтрүүлж,  
хэрэгжүүлж байгаа бол үүнтэй холбогдон гарсан зардлыг татвар ногдуулах зардлаас  
хасч тооцно.” гэж нэмэх.**

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл,  
Ё.Отгонбаяр, Л.Энх-Амгалан**

**4.Хуулийн төслийн 28.1.17 дахь заалтын “ажил олгогч хариуцна.” гэсний дараа  
“Ажилтны амь нас, эрүүл мэндийн даатгалд ажилтныг даатгуулсан нь Хөдөлмөрийн  
тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан нөхөн төлбөрийг ажил олгогч олгохгүй байх  
үндэслэл болохгүй.” гэж нэмэх.**

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн А.Тлейхан, Л.Энх-Амгалан**

**5.Хуулийн төслийн 28.3 дахь хэсгийн “гэрээнд тодорхой тусгана.” гэсний дараа  
“Хэрэв гэрээнд энэ талаар тусгаагүй бол тухайн асуудлыг ерөнхий гүйцэтгэгч хариуцна.”  
гэж нэмэх.**

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн А.Тлейхан, Л.Энх-Амгалан**

**Нийгмийн бодлого, боловсрол, соёл,  
шинжлэх ухааны байнгын хороо**

---oOo---